



**ӨМНӨГОВЬ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР**

Нутгийн удирдлагын ордон 204 тоот, 3 дугаар баг,  
Даланзадгад сум, Өмнөговь аймаг, 46083  
Утас: (976) 70532849, Факс: (976) 70532111  
Цахим шуудан: info@omnogovi.gov.mn  
Цахим хуудас: www.omnogovi.gov.mn

2024. 07. 19 № 02/2174

танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

**Мэдэгдэл хүргүүлэх тухай**

Бэлчээр усжуулалтын хоёрдугаар аяны хүрээнд инженерийн хийцтэй худаг шинээр гаргах, хуучин худгийг засварлаж бэлчээр усжуулалтыг нэмэгдүүлэх /тоноглох багц-4/ ажилд Ундрага Өмнөговь ХХК-с 2024 оны 07 дугаар сарын 04-ний өдрийн 01/92 тоот тодруулга хүссэн албан бичигтэй танилцлаа.

Тус ажлын ТШӨХ-д тусгагдсан комиссын дүгнэлтийг Монгол улсын Засгийн газрын 2021 оны “Дүрэм шинэчлэн батлах тухай” 212 дугаар тогтоолоор бус Хүнс, хөдөө аж ахуйн сайд, Байгаль орчны сайд, Сангийн сайдын 2005 оны №101/189/194 тоот хамтарсан тушаалаар батлагдсан журам, болон холбогдох бусад маягтуудаар инженерийн хийцтэй худгийн ажлыг хүлээн авах ажилд мөрддөг дүрэм журмыг дагуу тооцож болохыг тодруулж байна.

Үүнээс гадна “Бэлчээр усжуулалтын хоёрдугаар аяны хүрээнд инженерийн хийцтэй худаг шинээр гаргах, хуучин худгийг засварлаж бэлчээр усжуулалтыг нэмэгдүүлэх” /тоноглох багц-4/ ажлыг 2024 оны төсөв болон, хөгжлийн жилийн төлөвлөгөө, тухайн жилийн худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнүүдэд 4 дүгээр багц ажил болгон тусгасан тул дахин багцлах боломжгүйг үүгээр мэдэгдэж байна.

ДАРГА  ЦАМАРТӨГС



Data D:/zdtg2024/A4.TD.doc

4624072766